

“ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/054/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](#)
Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatar@audit.gov.mn](#)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](#)

Ахлах аудитор: С.Гансүх
Утас: 86479090 Цахим хаяг: [gansukhsa@audit.gov.mn](#)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](#)

Гүйцэтгэсэн аудитор: Д.Отгонбаяр
Утас: 99385356 Цахим хаяг:
[khaan.soyombo.audit@gmail.com](#)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/145
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
П.АРИУНСАН ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 84,997.0 мянган төгрөгийн цахим кабинет байгуулах хөрөнгө оруулалтын ажил хийгдэж ашиглалтанд оруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 15,671.9 мянган төгрөгийн алдаа, Төсвийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой илрүүлсэн 17,167.7 мянган төгрөгийн 4 зөрчил илрүүлж, 15,671.9 мянган төгрөгийн алдааг залруулж, илэрсэн зөрчлийг арилгах 4 зөвлөмж өгсөн.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал нь Боловсролын газрын даргатай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 хөтөлбөр, 93 арга хэмжээний хүрээнд 76.7 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6725021088

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>455,470,954.34</u>	<u>328,949,502.19</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	224,429,854.15	147,202,986.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	224,429,854.15	147,202,986.50
3121	Төгрөг	224,429,854.15	147,202,986.50
31211	Төрийн сангийн харилцах	224,429,854.15	147,202,986.50
33	АВЛАГА	175,244.93	74,215.73
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	175,244.93	74,215.73
35	БАРАА МАТЕРИАЛ	230,865,855.26	181,672,299.96
351	Түүхий эд материал	13,260,739.00	2,597,800.00
35110	Тусгай зориулалттай материал	10,453,839.00	00.00
35130	Эм боох материал	2,806,900.00	2,597,800.00
354	Хангамжийн материал	213,375,116.26	175,474,499.96
35410	Бичиг хэргийн материал	4,455,067.00	1,277,517.00
35420	Аж ахуйн материал	94,887,712.05	89,756,387.25
35440	Түлш, шатах тослох материал	69,845,000.00	5,900,000.00
35450	Барилгын засварын материал	2,809,125.00	1,056,425.00
35460	Хүнсний материал	7,560,578.00	38,139,551.00
35470	Бусад хангамжийн материал	33,817,634.21	39,344,619.71
35600	Мал амьтад	4230000.00	3600000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,445,812,433.18</u>	<u>2,548,689,330.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,445,812,433.18	2,548,689,330.01
392	Биет хөрөнгө	2,389,753,349.64	2,493,007,330.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,134,061,298.00	2,216,709,167.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-265,767,940.08	-330,295,094.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,746,018.00	94,546,018.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,746,018.00	-19,179,351.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	362,204,472.38	488,938,617.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	-136,283,174.60	-216,035,756.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	229,144,562.14	229,144,562.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	-90,675,454.04	-115,695,852.38
39214	Бусад үндсэн хөрөнгө	172,935,428.00	172,935,428.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-43,536,468.43	-57,633,972.07
39217	Ном	27,670,626.27	29,573,563.57
393	Биет бус хөрөнгө	56,059,083.54	55,682,000.00
39301	Програм хангамж	7,287,000.00	7,287,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,909,916.46	-7,287,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	55,682,000.00	55,682,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,901,283,387.52</u>	<u>2,877,638,832.20</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,063,765.27</u>	<u>60,206,206.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,063,765.27	21,249,252.00
412	Богино хугацаат зээлийн өглөг	00.00	21,249,252.00
4121	Төгрөг	00.00	21,249,252.00
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	00.00	21,249,252.00
413	Өглөг	5,063,765.27	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	788,883.27	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,010,418.00	00.00
4136	Бусад өглөг	2,264,464.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,264,464.00	00.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	38,956,954.00

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

422	Урт хугацаат зээл	00.00	38,956,954.00
4221	Төгрөг	00.00	38,956,954.00
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	00.00	38,956,954.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,896,219,622.25	2,817,432,626.20
51	Засгийн газрын хувь оролцоо	2,896,219,622.25	2,817,432,626.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,063,809,088.69	1,063,809,088.69
51101	Өмч: - төрийн	1,063,809,088.69	1,063,809,088.69
512	Хуримтлагдсан үр дүн	1,464,723,871.21	1,385,936,875.16
51210	Өмнөх үеийн үр дүн	1,129,600,047.21	1,129,600,047.21
51220	Тайлант үеийн үр дүн	335,123,824.00	256,336,827.95
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	367,686,662.35	367,686,662.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,901,283,387.52	2,877,638,832.20

2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,082,008,821.90	2,629,698,836.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,719,321.90	189,208,736.80
120	Нийтлэг татварын бус орлого	195,719,321.90	189,208,736.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	195,719,321.90	189,208,736.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,262,100.00	4,588,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,345,000.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,886,289,500.00	2,440,490,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,781,459,500.00	2,322,490,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,781,459,500.00	2,322,490,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	104,830,000.00	118,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104,830,000.00	118,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,745,624,997.90	2,708,205,832.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,745,624,997.90	2,708,205,832.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,677,688,849.86	2,632,195,444.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,208,914,716.92	1,862,164,536.42
210101	Үндсэн цалин	812,547,167.54	1,153,746,326.10
210102	Нэмэгдэл	336,684,327.10	639,860,596.32
210104	Урамшуулал	59,683,222.28	68,557,614.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,085,704.27	236,348,159.78
210201	Тэтгэврийн даатгал	102,773,704.27	159,708,380.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,077,700.00	18,635,902.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,663,100.00	9,150,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,415,800.00	9,150,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,155,400.00	39,703,077.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,444,575.96	166,933,075.16

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	22,860,325.96	25,298,975.16
210302	Түлш, халаалт	31,384,250.00	139,634,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,844,028.00	28,379,578.80
210401	Бичиг хэрэг	16,047,000.00	774,900.00
210402	Тээвэр, шатахуун	15,716,328.00	14,613,474.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,080,700.00	11,079,804.80
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,911,400.00
2105	Нормативт зардал	61,447,245.00	70,580,809.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	624,800.00	874,600.00
210502	Хоол, хүнс	60,822,445.00	69,706,209.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,443,000.00	15,431,300.00
210604	Урсгал засвар	30,443,000.00	15,431,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,186,300.00	8,537,030.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,186,300.00	4,390,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	4,146,630.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	132,323,279.71	243,820,954.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,502,100.00	33,922,300.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	21,690,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	101,821,179.71	188,208,054.47
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,936,148.04	76,010,388.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,011,474.00	75,998,464.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	67,011,474.00	75,998,464.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	924,674.04	11,924.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	924,674.04	11,924.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>336,383,824.00</u>	<u>-78,506,996.05</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,260,000.00	280,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,260,000.00	280,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,260,000.00	-280,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>335,123,824.00</u>	<u>-78,786,996.05</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00

C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,063,809,088.69	367,686,662.35	1,464,723,871.21	2,896,219,622.25
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,063,809,088.69	367,686,662.35	1,464,723,871.21	2,896,219,622.25
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,063,809,088.69	367,686,662.35	1,464,723,871.21	2,896,219,622.25
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-78,786,996.05	-78,786,996.05
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,063,809,088.69	367,686,662.35	1,385,936,875.16	2,817,432,626.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,897,896,600.00	2,445,148,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,607,100.00	4,658,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,607,100.00	4,658,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,607,100.00	4,658,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,262,100.00	4,588,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,345,000.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,886,289,500.00	2,440,490,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,781,459,500.00	2,322,490,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,781,459,500.00	2,322,490,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	104,830,000.00	118,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104,830,000.00	118,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,661,266,878.85	2,469,935,173.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,661,266,878.85	2,469,935,173.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,591,356,186.81	2,389,231,537.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,204,419,462.85	1,862,852,390.49
210101	Үндсэн цалин	808,051,913.47	1,154,434,180.17
210102	Нэмэгдэл	336,684,327.10	639,860,596.32
210104	Урамшуулал	59,683,222.28	68,557,614.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,159,920.00	236,348,159.78
210201	Тэтгэврийн даатгал	102,847,920.00	159,708,380.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,077,700.00	18,635,902.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,663,100.00	9,150,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,415,800.00	9,150,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,155,400.00	39,703,077.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,905,325.96	102,988,075.16
210301	Гэрэл, цахилгаан	22,860,325.96	23,399,884.98
210302	Түлш, халаалт	69,845,000.00	75,689,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	3,899,090.18
2105	Нормативт зардал	61,752,478.00	84,613,296.00
210502	Хоол, хүнс	61,752,478.00	84,613,296.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,712,100.00	17,305,660.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,432,100.00	4,489,600.00

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,280,000.00	12,816,060.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,406,900.00	70,123,956.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,593,900.00	54,185,056.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,813,000.00	15,938,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,910,692.04	80,703,635.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,986,018.00	80,691,711.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	68,986,018.00	80,691,711.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	924,674.04	11,924.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	924,674.04	11,924.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	236,629,721.15	-24,786,273.65
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,666,000.00	52,440,594.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,666,000.00	52,440,594.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,666,000.00	52,440,594.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,666,000.00	52,440,594.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-31,666,000.00	-52,440,594.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	204,963,721.15	-77,226,867.65
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,466,133.00	224,429,854.15
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	224,429,854.15	147,202,986.50

2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	224,429,854.15	(224,429,854.15)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,550,915,900.00	2,404,375,767.65	146,540,132.35	94.3
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,550,915,900.00	2,404,375,767.65	146,540,132.35	94.3
4	Бараа, үйлчилгээний зардал	2,470,224,100.00	2,323,684,056.65	146,540,043.35	94.1
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,970,568,400.00	1,862,852,390.49	107,716,009.51	94.5
6	Үндсэн цалин	1,300,105,800.00	1,154,434,180.17	145,671,619.83	88.8
7	Нэмэгдэл	640,464,700.00	639,860,596.32	604,103.68	99.9
9	Урамшуулал	29,997,900.00	68,557,614.00	(38,559,714.00)	228.5
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	246,321,000.00	236,348,159.78	9,972,840.22	95.9
12	Тэтгэврийн даатгал	167,498,400.00	159,708,380.00	7,790,020.00	95.3
13	Тэтгэмжийн даатгал	19,705,700.00	18,635,902.00	1,069,798.00	94.6
14	ҮОМШӨ ний даатгал	9,852,800.00	9,150,400.00	702,400.00	92.9
15	Ажилгүйдлийн даатгал	9,852,800.00	9,150,400.00	702,400.00	92.9
16	Эрүүл мэндийн даатгал	39,411,300.00	39,703,077.78	(291,777.78)	100.7
30	Нормативт зардал	84,613,500.00	84,613,296.00	204.00	100.0
32	Хоол, хүнс	84,613,500.00	84,613,296.00	204.00	100.0
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	43,281,600.00	17,305,660.38	25,975,939.62	39.98
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,489,600.00	4,489,600.00	-	100.0
49	Мэдээллийн технологийн зардал	38,792,000.00	12,816,060.38	25,975,939.62	33.0
53	Бараа үйлчилгээний бусад зардал	125,439,600.00	122,564,550.00	2,875,050.00	97.7
54	Бараа үйлчилгээний бусад зардал	109,500,700.00	106,625,650.00	2,875,050.00	97.4
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,938,900.00	15,938,900.00	-	100.0
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,691,800.00	80,691,711.00	89.00	100.0
70	Бусад урсгал шилжүүлэг	80,691,800.00	80,691,711.00	89.00	100.0
74	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	80,691,800.00	80,691,711.00	89.00	100.0
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,550,915,900.00	2,327,148,900.00	223,767,000.00	91.23
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,322,490,100.00	2,322,490,100.00	-	100.0

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

99	Улсын төсвөөс санхүүжих	2,322,490,100.00	2,322,490,100.00	-	100.0
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	228,425,800.00	4,658,800.00	223,767,000.00	2.0
111	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,489,600.00	4,588,800.00	(99,200.00)	102.2
112	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	70,000.00	-	100.0
113	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	223,866,200.00	-	223,866,200.00	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	224,429,854.15	(224,429,854.15)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	147,202,986.50	(147,202,986.50)	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	82.00	82.00	-	100.0
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
135	Гүйцэтгэх ажилтан	46.00	46.00	-	100.0
136	Үйлчлэх ажилтан	35.00	35.00	-	100.0

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	118,000,000.00	118,000,000.00	-	100.0
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	118,000,000.00	118,000,000.00	-	100.0
4	Бараа, үйлчилгээний зардал	118,000,000.00	117,988,075.16	11,924.84	99.9
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,000,000.00	102,988,075.16	11,924.84	99.9
18	Гэрэл цахилгаан	29,000,000.00	23,399,884.98	5,600,115.02	80.7
19	Түлш, халаалт	70,000,000.00	75,689,100.00	(5,689,100.00)	108.1
20	Цэвэр, бохир ус	4,000,000.00	3,899,090.18	100,909.82	97.5
34	Эд хогшил худалдан авах	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
38	Урсгал засвар	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	11,924.84	(11,924.84)	-
79	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	11,924.84	(11,924.84)	-
81	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,924.84	(11,924.84)	-
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	118,000,000.00	118,000,000.00	-	100.0
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	118,000,000.00	118,000,000.00	-	100.0
104	Орон нутгийн төсвөөс	118,000,000.00	118,000,000.00	-	100.0
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 15,671.9 мянган төгрөгийн 1 алдаа илрүүлж аудитын явцад залруулсан.

Бараа материалын тайланд 15,671.9 мянган төгрөгийн хүнсний материалыг тусгай зориулалтын материал гэж тусгасан алдааг хоол хүнсний материал дансанд тусгаж залруулсан.

Аудитаар төсвийн зарцуулалт, өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаатай холбоотой 17,167.8 мянган төгрөгийн 4 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчилийг арилгах 4 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой

1.1 Илрүүлэлт:

Тайлант онд Тарважтээл хоршоотой 21,434.9 мянган төгрөгөөр гурил, гурилан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулсан боловч, бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлж, гэрээний үнийн дүнгээс 13,450.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.11-д "гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэж байх.

2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой

2.1 Илрүүлэлт:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 25 нэр төрлийн 375,185.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эрх бүхий дээд шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх шатандаа байна. Энэ нь Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 10.42 (ж) "илүүдэл эд хөрөнгө болон элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоосон тохиолдолд хөрөнгийг данснаас хасаж, уг тогтоосон үнээр шинэ хөрөнгө хүлээн зөвшөөрнө. Мөн уг хөрөнгийн цаашид ашиглагдах хугацааг шинэчлэн тогтоож, элэгдэл байгуулна." гэж заасныг зөрчиж "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх.

3. Төсвийн зарцуулалттай холбоотой

3.1 Илрүүлэлт:

Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2024 оны 07 сарын 22-ны өдрийн Б/29 тоот тушаалаар нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад 2,942.0 мянган төгрөгийн урамшууллыг олгохдоо ажлын үр бүтээлийг үнэлсэн хангалттай баримтыг үндэслээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2,

Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулахдаа ажлын үр бүтээлийг үнэлж байх

4. Төсвийн зарцуулалттай холбоотой

4.1 Илрүүлэлт:

Тайлант онд хүүхдийн үдийн цайны нормативт зардлыг 774.9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 2022 оны 498 дугаар тогтоолын 2 дахь заалт "Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах ахлах ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4300 төгрөгөөр, бага, дунд ангийн нэг сурагчийн хоногийн хоолны зардлыг 4000 төгрөгөөр тогтоосугай" Засгийн газрын 2021 оны 237 дугаар тогтоолын 1-д "Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1500 (нэг мянга таван зуун) төгрөгөөр тогтоосугай" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Хүүхдийн үдийн цайны зардлын батлагдсан нормативыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хүнсний материалыг өөр дансанд бүртгэсэн	1	15,671.9			1	15,671.9	1	15,671.9				
Дүн	1	15,671.9			1	15,671.9	1	15,671.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Нягтлан бодох бүртгэлийн ажилтанд ажлын үр бүтээлийг үнэлэхгүй санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтэд үндэслэн балансын урамшуулал гэж олгосон.	1	2,942.0						1	2,942.0
Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй элэгдлээрээ өртгөө нөхсөн 375,185.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө	1	0						1	0
Хүүхдийн үдийн цайны нормативыг мөрдөөгүй	1	774.9						1	774.9
Дүн	3	3,716.9						3	3,716.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Гэрээний нөхцөл, үнийн дүнгээс хэтрүүлэн худалдан авалт хийсэн	1	13,450.8						1	13,450.8
Дүн	1	13,450.8						1	13,450.8